# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР




# 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭН ЖИЛИЙН ТАЙЛАН

**2024 он**

# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## ГАРЧИГ

**НЭГ. УДИРТГАЛ**

**ХОЁР. ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**

2.1. Захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үйл ажиллагаа

2.1.1. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хүргүүлсэн хууль тогтоомж, дүрэм, журмын төслийг тухай бүр шүүгч, ажилтнуудад танилцуулах, үр нөлөөтэй санал өгөх, энэ талаар хагас бүтэн жилээр тайлагнах

2.1.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалалд тулгуурлан 2025 онд зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай орон тооны саналыг үндэслэл бүхий судалгааны хамт Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх

2.1.3. “Шүүхийн Тамгын газрын мэдээллийн нэгдсэн сан”-ийн мэдээллийг сар бүр шинэчлэх

2.1.4. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн ач холбогдлын талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг улирал бүр хэрэгжүүлж, олон нийтэд сурталчлах

2.1.5. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрс шинэчлэгдсэнтэй холбогдуулан иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах

2.1.6. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах

**2.2.Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх**

2.2.1. Мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн технологийн чиглэлээр шүүгч, шүүхийн захиргааны албан хаагч нарт дотоод сургалтыг зохион байгуулах

2.2.2. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системд шүүхийн захиргааны нийт албан хаагчдыг бүртгэлжүүлж, цаг бүртгэлийн төхөөрөмжтэй холбох

2.2.3. Шүүхийн шийдвэрийн цахим хуудас /shuukh.mn/ дахь 2013-2023 оны шүүхийн шийдвэрүүдийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зөрчлийг бүрэн арилгасан байх

2.2.4. Шүүхийн шийдвэрийг цахим хуудас /shuukh.mn/-т шинээр байршуулахдаа журмын хэрэгжилтийг хангаж ажиллах

2.2.5. Байгууллагын дотоод сүлжээний топологи зургийг гаргаж, зохион байгуулалтыг сайжруулах

2.2.6. Хэргийн хөдөлгөөний хэрэгжилтэд сар бүр дотоод хяналт тавьж, тайланг загварын дагуу гаргаж, Ерөнхий зөвлөлд хүргүүлэх

2.2.7. Хэргийн хөдөлгөөний чиглэлээр дотоод сургалтыг улирал бүр зохион байгуулах

**2.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

2.3.1 Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгож, шүүх хуралдаанд оролцуулах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, хяналт-шинжилгээний үр дүнг үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хагас, бүтэн жилээр Ерөнхий зөвлөлд хүргүүлэх

2.3.2. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг тавьж ажиллах

2.3.3. Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураагдсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүлээж авах, шийдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

**2.4. Шүүхийн тусгай архивын чиглэлээр**

2.4.1. Архивын данс, бүртгэлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн хөтөлж, нэгдсэн тооллогын мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх

2.4.2. Архивчийг мэргэшүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах

2.4.3. Шүүхийн Тамгын газрын дотоод нөөц бололцоонд тулгуурлан архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлэх

2.4.4. Хадгалах хугацаа дууссан архивын баримтын жагсаалтыг ШТА-ын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулах, баримт устгах ажиллагааг журамд заасны дагуу зохион байгуулах

**ГУРАВ. ШҮҮХИЙГ ХҮНИЙ НӨӨЦӨӨР ХАНГАХ**

3.1.1. Шүүхийн захиргааны хүний нөөцийн эрсдэлийн судалгааны саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх

3.1.2. Шүүхийн захиргааны ажилтанд хүний эрхийг дээдлэх харилцаа, хандлага, ур чадвар, ёс зүйг төлөвшүүлэх, гүйцэтгэлийн стандартын төсөлд саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх

3.1.3. Ёс зүйн дэд хороо байгуулж, шүүхийн захиргааны ажилтан сахилга, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ авч, тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ёс зүйн хороонд хүргүүлэх

3.1.4. Шүүхийн тамгын газрын ажилтны хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хүний нөөцийн мэдээллийн санг баяжуулж, ашиглах

3.1.5. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг Монгол Улсын төрийн одон, медаль, цол, тэмдэг болон салбарын шагналд уламжлах

3.1.6. Шүүхийн тамгын газрын албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу хөтөлж, хяналт тавих

3.1.7. “Шүүхийн захиргааны цахим сургалтын систем”-д байршсан хичээлүүдийг бүрэн судалсан байх

3.1.8. Шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан сургалтын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх

3.1.9. Шүүгчийн хүний нөөцийн программд холбогдох мэдээ, мэдээллийг бүрэн бүртгэж, баяжилтыг тухай бүр хийж, энэ талаар шүүгчид хагас, бүтэн жилээр танилцуулах

## ДӨРӨВ. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ

4.1.1. Шүүгчээс хөтөлсөн нөлөөллийн мэдүүлэг, тэмдэглэлийг холбогдох журамд заасны дагуу нууцлалыг хангаж, Ерөнхий зөвлөлд хүргүүлэх, нөлөөллийн мэдүүлэгт нотлох баримт бүрдүүлэхэд шүүгчид дэмжлэг үзүүлэх

4.1.2. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3, 44.4 дэх хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон бол Ерөнхий зөвлөлд нэн даруй мэдэгдэх

4.1.3. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд уг шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, энэ талаар Ерөнхий зөвлөлд нэн даруй мэдэгдэж, холбогдох арга хэмжээ авах

4.1.4. Цагдаагийн байгууллагатай “Хамтран ажиллах төлөвлөгөө”-г баталж, хэрэгжүүлэх

4.1.5. Шүүгчийг хуулиар зөвшөөрсөн бие хамгаалах тусгай хэрэгсэл ашиглах талаар холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах

4.1.6. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах ажлыг холбогдох журамд заасны дагуу цагдаагийн байгууллагатай хамтран шуурхай зохион байгуулж, энэ талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд даруй мэдэгдэх

4.1.7. Шүүх хуралдааны аюулгүй байдлыг зохих журам, стандартын дагуу хангах, шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах

4.1.8. Албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаанд тогтмол хяналт тавьж, цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах, журамд заасны дагуу албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагааны мэдээллийг цагдаагийн байгууллагаас тухай бүр авч, дүн шинжилгээ хийж, тухайн шүүхэд улирал тутамд танилцуулах

4.1.9. Шүүгч, ажилтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах ажлыг зохион байгуулж, холбогдох тайлан мэдээг батлагдсан маягтын дагуу шуурхай ирүүлэх

4.1.10. Шүүгчийн хараат бус байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд хандсан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах

## ТАВ. ШҮҮХИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

5.1.1. Батлагдсан төсөв, цалингийн сан, орон тоонд багтаан төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулах, бүртгэх, тайлагнах ажлыг зохион байгуулах

5.1.2. Шүүхийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, норм стандартын дагуу үндэслэлтэй боловсруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх

5.1.3. Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг иж бүрэн, үнэн зөв, хуульд заасан хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид сар, улирал бүр хүргүүлэх

5.1.4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

5.1.5. Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангах

5.1.6. Ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах, шилжүүлэх эсхүл худалдах асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлүүлж, биелэлтийг хангаж ажиллах

5.1.7. Цалин хөлс, татвар, даатгалын тайлангийн уялдааг хангаж, өр, авлагагүй ажиллах

5.1.8. Төрийн цахим худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайтыг ашиглан, ил тод, нээлттэй байлгаж, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэн ажиллах

5.1.9. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд www.shilendans.gov.mn сайтад үнэн зөв, иж бүрэн байршуулахад хяналт тавих

**ЗУРГАА. МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР**

6.1.1. Шүүх өөрийн цахим хуудсаар шийдвэр, үйл ажиллагаагаа тогтмол мэдээлж ажиллах

6.1.2. Шүүх хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулах

6.1.3. Шүүхийн шийдвэрийг ойлгомжтой байдлаар олон нийтэд тухай бүр, шуурхай мэдээлж, статистик мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх

6.1.4. Хуулиар хориглосноос бусад тохиолдолд шүүх хуралдааныг “Шүүхийн мэдээ” цахим хуудсаар олон нийтэд хүргэх

6.1.5. Шүүгч ажилтны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, нийтлэлийг бүртгэж, тухайн шүүхийн шүүгчдэд танилцуулах, холбогдох арга хэмжээ авах

6.1.6. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшинг тодорхойлох судалгаа хийж, тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх

6.1.7. Нээлттэй шүүх өдөрлөгийг улирал тутам зохион байгуулж, олон нийтэд шүүхийн үйл ажиллагааг сурталчлах

6.1.8. Иргэдийн эрх зүйн боловсролд зориулсан мэдээллийг улирал тутамд олон нийтэд түгээх

**ДОЛОО. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД**

# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024.12.02 Сайншанд сум.

## НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн жил хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн тэргүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам”-д тус тус заасны дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг төлөвлөсөн хугацаанд нь хийж гүйцэтгэн, хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллалаа.

Дорноговь аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь 2024 онд Дорноговь аймгийн Эрүү, Иргэнийн хэргийн давж заалдах шатны шүүх, Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх гэсэн бүтэцтэйгээр, нийт 11 шүүгч, Төрийн захиргааны 15, Төрийн үйлчилгээний 10, нийт 39 орон тоо батлагдсанаас 36 орон тоотой, 2,352,713,100.00 төгрөгийн төсөвтэйгөөр шүүн таслах ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. “Шүүхийн бие даасан байдлыг хангах” чиглэлээр:
   1.1. Шүүхийн захиргаа,удирдлага-6
   1.2. Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлага-7;
   1.3. Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх-3
   1.4. Шүүхийн тусгай архив-4
2. “Шүүхийн хүний нөөцийг удирдах” чиглэлээр -9
3. “Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” чиглэлээр-10
4. “Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах” чиглэлээр -9
5. “Мэдээллээр хангах” чиглэлээр-8 ажил тус тус төлөвлөж, төлөвлөгөөний дагуу ажлыг дараах байдлаар хийж гүйцэтгэлээ.

## ХОЁР. ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

**2.1. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хүргүүлсэн хууль тогтоомж, дүрэм, журмын төслийг тухай бүр шүүгч, ажилтнуудад танилцуулах, үр нөлөөтэй санал өгөх, энэ талаар хагас бүтэн жилээр тайлагнах:**

2.1.1. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хүргүүлсэн хууль тогтоомж, дүрэм, журмын төслийг тухай бүр шүүгч, ажилтнуудад танилцуулах ажлын хүрээнд 20 бичиг ирүүлснээс 20 цаг хугацаанд нь хариуг хүргүүллээ.

| № | Ирсэн бичгийн огноо, дугаар | Ирүүлсэн байгууллага | Товч утга | Явуулсан бичиг |
|---|---|---|---|---|
| 1. | 2024.01.05 | Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс | 2023 онд Эрүү, Иргэн,захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулах санал | 2024.01.10-ны өдрийн Excel файл хүснэгтийн дагуу ecase@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 2. | 2024.01.19 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журам-д нэмэлт өөрчлөлт оруулах санал авах тухай | 2024.01.22-ны өдрийн Word файл хүснэгтийн дагуу battsengel@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 3. | 2024.01.29 №04/165 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журам-д нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолыг төслийг ерөнхий шүүгч нарын санал авах тухай | 2024.02.20-ны өдрийн №35 дугаартай албан бичгээр gunzayabayar@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 4. | 2024.02.13 | Мэдээлэл технологийн газар | Шүүхийн захиргааны байгууллагад цахим шуудан ашиглан баримт бичиг илгээх, хүлээн авах журмын төсөлд оруулах санал ирүүлэх тухай | 2024.02.16-ны өдрийн №31 дугаартай албан бичгээр zorigtzaya@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 5. | 2024.02.16 №01/287 | Шүүхийн ерөнхий зөвлөл | 2025 онд зайлшгүй нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага үүсэж буй орон тооны саналыг хуулийн үндэслэл, ажлын ачаалал, зохих судалгаанд тулгуурлан боловсруулж, шүүгчийн зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн саналыг ирүүлэх тухай | 2024.03.15-ны өдрийн №52 дугаартай албан бичгээр odmaa@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **6.** | 2024.03.04 №01/450 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журамын холбогдох зүйл, хэсэг,заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар нэмэлт, өөрчлөлтийн төслийг танилцуулж, саналаа ирүүлэх тухай | 2024.03.07-ны өдрийн №49 дугаартай албан бичгээр soyolmaa@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| **7.** | 2024.03.21 | Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс | “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар тухай | 2024.03.22-ны өдрийн word файлаар ecase@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| **8.** | 2024.03.22 | Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс | “Захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой саналаа ирүүлэх тухай | 2024.03.27-ны өдрийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 19 дугаартай албан бичгээр ecase@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| **9.** | 2024.04.02 | Шүүхийн Ерөнхий зөвлөл | 2025 онд хэрэгжих шүүгчийн амь нас,эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлэх компанийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулахтай холбогдуулан уг гэрээнд тусгах нэмэлт өөрчлөлтийн талаарх шүүгчдийн саналыг нэгтгэж ирүүлэх | 2024.04.11-ны өдрийн 74 дугаартай албан бичгээр contact@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| **10.** | 2024.04.30 №1/1994 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2024.05.02-ны өдрийн 89 дугаартай албан бичгээр administration@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| **11.** | 2024.06.27 №03/1168 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг аргачлалын төсөлд нэмж тусган Эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч нараас санал авах тухай | 2024.07.01-ны och@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 12. | 2024.08.21 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Монгол Улсын эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн бүтэн жилийн статистик тайлан мэдээний маягт"-ын төслийг Ерөнхий шүүгч, шүүгч болон шүүхийн захиргааны ажилтнуудад танилцуулж, холбогдох санал авах тухай | 2024.08.26-ны өдрийн 154 дугаартай албан бичгээр jud_research@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 13. | 2024.09.10 №02/4507 | Монгол Улсын Дээд шүүх | Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн үйл ажиллагаа, улдаа холбоонд холбогдох зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэхээр хуулийн холбогдох зохицуулалтыг сонгон авч судалж байгаа бөгөөд энэ талаар нийт шүүгч нарын санал авах тухай | 2024.09.10-ны өдрийн <eruusudalgaa@supremecourt.mn> хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 14. | 2024.09.10 №03/1452 | Шүүхийн Ерөнхий зөвлөл | Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал болон баримтын загварт санал авах тухай | 2024.09.16-ны өдрийн №176 дугаартай албан бичгээр ecase@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 15. | 2024.10.01 | Хэргийн хөдөлгөөний удирлага статистикийн газар | Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалын төсөлд санал авах тухай | 2024.10.03 №177, 2024.10.03 №563 дугаартай албан бичгээр ecase@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 16. | 2024.10.08 | Монгол Улсын Дээд шүүх Шүүхийн академи | Сургалтын санал ирүүлэх тухай | 2024.10.28-ны өдөр хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 17. | 2024.10.09 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Албан тушаалын тодорхойлолтод тусгах саналаа ирүүлэх тухай | 2024.10.10-ны өдрийн №191 дугаартай албан бичгээр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | munkhtsetseg@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 18. | 2024.10.24 №03/1714 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл хүргүүлж, санал авах тухай | 2024.10.28 №203 дугаартай албан бичгээр administration@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 19. | 2024.10.28 №1/6509 | Шүүхийн тусгай архив | Архивын ерөнхий газраас ирүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-д санал авах тухай | 2024.10.31 №208 дугаартай албан бичгээр uuganzaya@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. |
| 20. | 2024.11.06 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн сайдаас Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хэвлэл мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлд санал авахаар албан бичиг ирүүлсэн байна. | 2024.11.11-ний өдөр administration@judcouncil.mn хаягаар хариуг хүргүүлсэн. . |

**2.1.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалалд тулгуурлан 2025 онд зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай орон тооны саналыг үндэслэл бүхий судалгааны хамт Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх:**

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалалд тулгуурлан 2025 онд зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай орон тооны саналыг үндэслэл бүхий судалгааг тамгын газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 47 тоот албан бичгээр хүргүүллээ.


ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Тамгын газрын дарга

015200035

**2.1.3. “Шүүхийн Тамгын газрын мэдээллийн нэгдсэн сан”-ийн мэдээллийг сар бүр шинэчлэх:**

Шүүхийн Тамгын газрын мэдээллийн нэгдсэн сан”-ийн мэдээллийг сар бүрийн 25-ны өдөр хугацаанд нь нийт 11 удаа шинэчилж хэвшсэн.


ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Шүүхийн ерөнхий зөвлөл | Шүүхийн цахим сан | Мэдээлэл нэмэх | Мэдээлэл засварлах | Системээс гарах

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

dornogovi | 285 | хэвлэх

| Д/д | Өгөгдөл | Мэдээлэл |
|---|---|---|
| 1 | Харьяалах нутаг дэвсгэр, хүн ам | Дорноговь аймаг нь 109.5 м2 газар нутагтай бөгөөд тус шүүх нь Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Мандах, Иххэт, Хөвсгөл, Хатанбулаг, сумдыг харьяалан ажилладаг. Харьяалах нутаг дэвсгэр нь 47236 хүн амтай. |
| 2 | Шүүхийн тамгын газрын харьяалж үйлчлэх шүүх | Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дорноговь аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Дорноговь аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх, Дорноговь аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх |
| | **Шүүхийн байр** | |
| 1 | Шүүх өөрийн байртай эсэх, 1 байранд хэдэн шүүх үйл ажиллагаа явуулдаг, прокуроортой хамт байдаг эсэх/ | Тус шүүх нь өөрийн байртай бөгөөд уг байранд аймгийн Прокурорын газартай хамт байрлан ажиллаж байна. |

**2.1.4. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн ач холбогдлын талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг улирал бүр хэрэгжүүлж, олон нийтэд сурталчлах:**

Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газраас Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн ач холбогдлын талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг улирал бүр хэрэгжүүлж, олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 2024 онд 8 удаагийн сургалт, мэдээлэл хүргэж гарын авлага тараан ажиллалаа.

1. 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Чандмань-Илч ОНӨХХК-ны ажилтнуудад




2. 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Дорноговь аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг, “Хуульчийн Про Боно” өдөрлөгт



3. 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Улаанбаатар төмөр замын Дохиолол холбооны 3 дугаар ангийн ажилтнуудад



4. 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Сайншанд сумын “Шинэ зуун” үйлчилгээний төвийн түрээслэгч, өмчлөгч нарт



5. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Дорноговь аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын талбайд зохион байгуулагдсан гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа газруудын “нээлттэй хаалганы өдөрлөгт”




6. 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Сайншанд сумын 5 дугаар баг Зүүнбаян багийн ажлын албаны ажилтнуудад



7. 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Сайншанд сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн багш ажилтнуудад




8. 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Доншен петролиум ХХК-ны ажилтнуудад эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн ач холбогдлын талаар сургалт мэдээлэл өгсөн ба 2024 оны 10, 11 дүгээр сард эвлэрүүлэн зуучлалын 2 удаагийн уулзалтыг Зүүнбаян багт зохион байгууллаа.



**2.1.5. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрс шинэчлэгдсэнтэй холбогдуулан иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах:**

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрс шинэчлэгдсэнтэй холбогдуулан 2023-2024 онд Дорноговь аймгийн Хөвсгөл, Хатанбулаг, Мандах, Сайхандулаан, Сайншанд сумдаас сонгогдсон иргэдийн төлөөлөгчдөд сургалтыг зохион байгуулж гарын авлага тараан ажиллалаа.



**2.1.6. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах:**

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 5 удаагийн сургалт мэдээллийг өглөө Үүнд:

1. 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Дорноговь аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг, “Хуульчийн Про Боно” өдөрлөгт ирсэн иргэдэд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай танилцуулан гарын авлага материал тараан ажиллалаа.



2. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Дорноговь аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын талбайд зохион байгуулагдсан гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа газруудын “нээлттэй хаалганы өдөрлөгт” оролцож Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай танилцуулан гарын авлага материал тараан ажиллалаа.



3. 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Сайншанд сумын 5 дугаар баг буюу Зүүнбаян багийн ажлын албаны ажилтнуудад

4. 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Сайншанд сумын 5 дугаар баг Зүүнбаян багийн Сайншанд сумын 4 дүгээр сургууль багш, ажилтнуудад



5. 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Сайншанд сумын 5 дугаар баг Зүүнбаян багт Доншен петролиум ХХК-ны ажилтнуудад



## 2.2.Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх

### 2.2.1. Мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн технологийн чиглэлээр шүүгч, шүүхийн захиргааны албан хаагч нарт дотоод сургалтыг зохион байгуулах:

Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газраас 2024 оны А/08 дугаартай тушаалаар дотоод сургалтын төлөвлөгөөг батлсны дагуу мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн технологийн чиглэлээр шүүгч, шүүхийн захиргааны албан хаагч нарт 4 удаагийн дотоод сургалтыг зохион байгууллаа. Үүнд:

1. 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “Компьютерын анхан шатны хэрэглээ”,



2. 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр “Шүүх хуралдааны тоног төхөөрөмжийг ашиглахтай тухай зааварчилгаа”,






3. 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр “Цахим орчинд анхаарах зүйлс” “Мэдээллийн аюулгүй байдал” сэдэвт сургалт.



4. 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр “Хэрэглэгчийн нууц үгийн хамгаалалт, хувийн мэдээлэл, компьютерын аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллах”




5. 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр “Дорноговь аймаг дахь шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт Е-токен буюу тоон гарын үсгийн төхөөрөмж”



**2.2.2. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системд шүүхийн захиргааны нийт албан хаагчдыг бүртгэлжүүлж, цаг бүртгэлийн төхөөрөмжтэй холбох:**

ERP системээр төрийн байгууллагуудын албан бичгийг хүлээн авч байгаа. Уг системд нийт албан хаагчдыг бүртгэлжүүлж, цагийн бүртгэл, дотооддоо албан бичгийг дамжуулж, хүсэлт гаргах, албан томилолт бүртгэх, ээлжийн амралтыг, цагийн бүртгэл хийх зэргээр ашиглаж хэвшсэн. Цаг бүртгэлийг сар бүрийн эхэнд Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлж байна.



Мөн шүүгчдийн чөлөөний мэдээллийг сарын бүрийн эхэнд shuugch-hr@judcouncil.mn хаягаар хүргүүлж хэвшлээ.

**2.2.3. Шүүхийн шийдвэрийн цахим хуудас /shuukh.mn/ дахь 2013-2023 оны шүүхийн шийдвэрүүдийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зөрчлийг бүрэн арилгасан байх:**

Шүүхийн шийдвэрийн цахим хуудас /shuukh.mn/ дахь 2013-2023 оны шүүхийн шийдвэрүүдийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зөрчлийг бүрэн арилгасан болно.



**2.2.4.Шүүхийн шийдвэрийг цахим хуудас /shuukh.mn/-т шинээр байршуулахдаа журмын хэрэгжилтийг хангаж ажиллах:**

Журмын хэрэгжилтийг ханган Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу зөрчлийг арилган эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 1635 иргэний хэргийн анхан шатны шүүхийн 1587 Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 193 давж заалдах шатны шүүхийн магадлал иргэн 275 Давах заалдах шатны шүүхийн магадлал эрүү 526 нийт 3946 шийдвэрийг байршууллаа.

**2.2.5. Байгууллагын дотоод сүлжээний топологи зургийг гаргаж, зохион байгуулалтыг сайжруулах:**

Байгууллагын дотоод сүлжээний Топологи зургийг гарган 2024 оны 03 дугаар сарын 10-ны өдөр гарган зохион байгуулалтыг сайжруулан ажиллаж байна.




**2.2.6. Хэргийн хөдөлгөөний хэрэгжилтэд сар бүр дотоод хяналт тавьж, тайланг загварын дагуу гаргаж, Ерөнхий зөвлөлд хүргүүлэх:**

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр баталж уг төлөвлөгөөний дагуу хийсэн хяналт шалгалтын тайлан дүн мэдээг шүүгч, ажилтнуудын нэгдсэн хуралдаанаар танилцуулсан бөгөөд шалгалтаар илэрсэн зөрчлийн дагуу шүүхийн захиргааны ажилтнуудад хугацаатай үүрэг даалгавар өгч алдаа дутагдлыг арилгуулан ажиллаж байна. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 158 дугаар тогтоолоор баталсан “Хэргийн хөдөлгөөний хяналтын журам”-ын дагуу сар болгон хяналт, шалгалтыг зохион байгуулж 3 дугаар улирлын тайланг Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхүүдэд танилцуулан хүргүүлэн ажиллалаа.



Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 158 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2024 оны 10 сарын 03-ны өдөр Дугаар 01 Сайншанд сум

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 158 дугаар тогтоолын дагуу дараах чиглэлээр хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

Хамрах хугацаа: 2024.06.21-09.30

| Д/д | Хяналт шалгалтын төрөл | Хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил | Хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 1. | Шүүгчийн зөвлөгөөний тогтоолоор баталсан "Хэрэг нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сүлжээгээр томилох нарийвчилсан журам"-ыг нэгдсэн системд тохируулсныг шалгах магт | - | |
| 2. | Шүүхийн шийдвэрийг холбогдох журмын дагуу байршуулсныг шалгах магт | 28 /эрүү/ 2 /иргэн/ | Шалгалтын явцад байршуулаагүй байсан 28 шийтгэх тогтоол, 2 шийдвэрийг нэн даруй холбогдох хууль журамд нийцүүлэн байршуулсан болно. |
| 3. | Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим систем ашиглалтыг шалгах магт | 1 /Давах эрүү/ 1 /эрүү анхан/ 2 / иргэн анхан/ | 7 хоног бүрийн тамгын газрын шуурхай хуралдаанд цахим систем ашиглалтын мэдээг танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. |



ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

**Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ:** Засварлагдах боломжтой алдаануудыг тухай бүр нь засварлуулан, дахин давтан гаргуулахгүй байх тал дээр онцгой анхааран ажиллаж байна. Дотоод сургалтыг эрчимжүүлж гаргасан алдаа зөрчлийн агуулгаар сургалтын сэдвийг нэмэлтээр оруулж, хяналтыг сайжруулж ажиллана.

**Тамгын газрын дүгнэлт:** Гар бүртгэл Шүүгчийн туслах, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, захиргааны зөвлөх ажилтан, архив, бичиг хэргийн эрхлэгч, бичиг хөтлөгч нарын нийтлэг гаргаж байгаа алдаа нь ихэвчлэн гар бүртгэлийг хөтлөхдөө нарийн тайлал, огноо, бүртгэлийн хаалтыг хийдэггүй нийтлэг алдаа гаргаж байна.

Программын ажиллагааны тухайд: Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар лайв хөтлөхдөө 3-аас дээш үйлдэл хийгээгүй 4 алдаа, шүүх хуралдааны тэмдэглэл хугацаандаа гараагүй 33 тэмдэглэл байв.

Цаашид дээрх алдаа зөрчил гаргахгүй байх тал дээр анхаарч, сар бүр хяналт шалгалтаар холбогдох программ болон журмуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд алдаа зөрчилгүй ягштал мөрдүүлж ажиллах, гаргасан зөрчлийн агуулгаар дотоод сургалт зохион байгуулж чадавхжуулах нь зүйтэй байна.

**Тамгын газрын санал:** Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулахдаа хэрхэн баталгаа гаргуулсныг шалгах явцад шүүх хуралдааны төв мэдээлэлд биечлэн оролцоно гэж мэдэгдсэн боловч яг хурал орох үед гэнэт цахимаар оролцоно гээд хуралдаа шууд цахимаар оролцдог. Мөн ахмад настан, бичиг үсэг мэдэхгүй, хөдөө орон нутагт байдаг хүмүүс цахимаар орно гэдэг боловч баталгааны хуудастай танилцаж гарын үсэг зурах боломж байхгүй, е-мэйл хаяг болон цахим хаяг байхгүй, хэвлэх төхөөрөмж байхгүй гэдэг хүндрэл байдаг учраас алдаа зөрчилд тооцоход дутагдалтай.

Дотоод хяналт шалгалт хийсэн
Тамгын газрын дарга /С.Бурмаа/
Албан тушаал гарын үсэг

**2.2.7. Хэргийн хөдөлгөөний чиглэлээр дотоод сургалтыг улирал бүр зохион байгуулах:**

Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/08 дугаартай тушаалаар дотоод сургалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд хэргийн хөдөлгөөний чиглэлээр улирал бүр сургалт зохион байгуулах ажлын хүрээнд 6 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Үүнд:

1. 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр шүүгчийн туслах Э.Болорцэцэг "Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийн хэрэглээ" сэдвээр,



2. 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр шүүгчийн туслах Ц.Тэгшдүүрэн “Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн бүртгэл хяналтын нэгдсэн системийн хэрэглээ” сэдвээр



3. 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр мэдээлэл лавлагааны мэргэжилтэн О.Батбямба “Шүүх хуралдааны тоног төхөөрөмж ашиглах”, “Зүүм программын ашиглалт” сэдвээр



4. 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдөр шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Э.Намуунзул “Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт зориулсан” сэдвээр




5. 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Орхон аймаг дахь шүүхийн Тамгын газрын дарга Б.Батцэцэг “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний алдаа зөрчил, анхаарах асуудал” сэдвээр



6. 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Шүүгчийн туслах А.Баяржаргал нь шинээр томилогдож буй шүүгчийн туслахуудад зориулан “Иргэний хэргийн программ хэрэглээ, тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр



**2.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

**2.3.1 Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгож, шүүх хуралдаанд оролцуулах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, хяналт-шинжилгээний үр дүнг үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хагас, бүтэн жилээр Ерөнхий зөвлөлд хүргүүлэх:**

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгож, шүүх хуралдаанд оролцуулах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, хяналт-шинжилгээний үр дүнг үндэслэн тайланг дотооддоо гаргаж дүн шинжилгээ хийн иргэдийн төлөөлөгчдөд зориулсан сургалтын мэдээллийг шинэчлэн боловсруулж цаашид иргэдийн төлөөлөгчийн сургалтыг чанаржуулсан бөгөөд 2024 онд анхан шатны шүүх хуралдаанд 22 иргэдийн төлөөлөгч оролцож иргэдийн төлөөлөгчөөс шалтгаалан шүүх хуралдаан хойшилсон тохиолдол гараагүй байна.

**2.3.2. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг тавьж ажиллах:**

Долоо хоног бүр тамгын газрын шуурхай хуралдааныг зохион байгуулж хэвшсэн бөгөөд шуурхай хуралдаанд архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны мэдээ авч, хяналт тавин ажилладаг. Мөн Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын даргын баталсан “Хэргийн хөдөлгөөний чиглэлээр хийгдэх хяналт шалгалт”-ын төлөвлөгөөнд албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийх

хяналт шалгалтыг багтаасан бөгөөд 1, 2, 3 дугаар улирлын байдлаар хяналт шалгалтыг зохион байгуулсан.

**2.3.3. Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураагдсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүлээж авах, шийдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх:**

Тамгын газрын даргын 2024 оны А/02, А/26 дугаар тушаалаар эд мөрийн баримт устгах, шийдвэрлэх комиссыг шинэчлэн байгуулсан бөгөөд эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураагдсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүлээж авах, шийдвэрлэхтэй холбогдуулан эд мөрийн баримт шийдвэрлэх комисс 4 удаа хуралдаж, 2 удаа эд мөрийн баримтыг устгаад байна.





Мөн эд мөрийн баримтын өрөөнд давхар хаалга хийж галын хорыг шинээр авч байршууллаа.





**2.4. Шүүхийн тусгай архивын чиглэлээр**

**2.4.1 Архивын данс, бүртгэлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн хөтөлж, нэгдсэн тооллогын мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх:**

Архивын данс, бүртгэлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн хөтөлж эхэлсэн бөгөөд архивын өрөөг стандартын дагуу засварлаж нягтаршуулсан шүүгээг байрлуулан, данс бүртгэлээр нэг бүрчлэн тулган хэрэг, баримтуудыг байршуулж байна. Нийт 35,592 хадгаламжийн нэгж байна.

**2.4.2. Архивчийг мэргэшүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах:**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн тусгай архиваас зохион байгуулсан цахим сургалтад архив, бичиг хэргийн эрхлэгч 2 удаа хамрагдсан болно.

**2.4.3. Шүүхийн Тамгын газрын дотоод нөөц бололцоонд тулгуурлан архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлэх:**

1975-2023 оны архив баримт бичиг цахимжуулж, 35592 ХН-ээс 9876ХН-ийг цахимжуулсан болно.

**2.4.4 Хадгалах хугацаа дууссан архивын баримтын жагсаалтыг ШТА-ын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулах, баримт устгах ажиллагааг журамд заасны дагуу зохион байгуулах:**

2024 оны А/01, А/25 дугаартай тушаалаар БНШАЗК-ыг шинэчлэн байгуулсан. Архив бичиг хэргийн эрхлэгч устгах хэргийг жагсаалтыг үйлдэн БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

**Дүн шинжилгээ:**

Шүүхийн Тамгын газраас ERP системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж хууль тогтоомж, дүрэм журам, аргачлал, стандартын нэгдсэн сан бүрдүүлсэн бөгөөд шүүгч, шүүхийн захиргааны ажилтны хоорондын ажил хэргийн харилцааг баримтжуулах, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох дэвшил болсон.

Хэргийн хөдөлгөөн болон эвлэрүүлэн зуучлал, иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэдэд зориулсан дотоод болон гадагш чиглэсэн сургалт үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулж оролцсон бөгөөд сургалт, мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулан шүүхийн үйл ажиллагааг иргэдэд түгээн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасны дагуу бүрэн гүйцэд хийж гүйцэтгэлээ.

## ГУРАВ. ШҮҮХИЙГ ХҮНИЙ НӨӨЦӨӨР ХАНГАХ

**3.1. Шүүхийн захиргааны хүний нөөцийн эрсдэлийн судалгааны саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх:**

2024 онд 8 ажилтан шинээр томилогдож /төрийн захиргааны 5, төрийн үйлчилгээний 3/ 2 ажилтан өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, 2 ажилтан шилжин томилогдсон бөгөөд 2023 онд зарлагдсан орон тоонууд нөхөгдөж шинээр 2 орон тооны захиалгыг хүргүүлээд байна.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР
44101 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Дорноговь аймгийн шүүхийн байр,
Утас/Факс: (976) 70522339
E-mail: dornogovi_tg@shuukh.mn
2023.09.22 № 154
танай ______ -ны № ______ -т

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛД

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газрын үйлчилгээний хэлтсийн шүүгчийн туслах 2, мэдээллийн технологийн мэргэжилтэн 1, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн 1 сул орон тооны захиалгыг хүргүүлж байна.

Холбогдох материалыг хавсаргав.

ДАРГА С.БУРМАА

015300275

**3.2 Шүүхийн захиргааны ажилтанд хүний эрхийг дээдлэх харилцаа, хандлага, ур чадвар, ёс зүйг төлөвшүүлэх, гүйцэтгэлийн стандартын төсөлд саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх:**

Шүүхийн захиргааны ажилтанд хүний эрхийг дээдлэх харилцаа, хандлага, ур чадвар, ёс зүйг төлөвшүүлэх, гүйцэтгэлийн стандартын төсөл 2024 онд ирээгүй болно.

**3.3. Ёс зүйн дэд хороо байгуулж, шүүхийн захиргааны ажилтан сахилга, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ авч, тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ёс зүйн хороонд хүргүүлэх:**

Тамгын газрын даргын 2024 оны А/03 дугаартай тушаалаар Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, шүүхийн захиргааны ажилтан сахилга, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөөг баталж 6 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 03/72

дугаар албан бичгийн дагуу 2024.01.11-ний өдөр мөн 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр тус тус тайланг хүргүүлсэн. Дараах сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:

БАТЛАВ:
ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.БУРМАА

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.01.08 Сайншанд сум

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах эзэн, хамтран ажиллах байгууллага |
|---|---|---|---|
| Нэг.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд | | | |
| 1 | Шинээр томилогдсон албан хаагч нарт сургалт зохион байгуулах | Тухай бүр | Э.Болорцэцэг |
| 2 | “Шүүгчийн ёс зүй” анхаарал асуудлууд | 2024 оны 1 дүгээр улирал | Шүүгч Ц.Ариунзул |
| 3 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлага | 2024 оны 1 дүгээр улирал | А.Баяржаргал |
| 4 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гомдол, мэдээлэл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх | 2024 оны 1 дүгээр улирал | А.Баяржаргал |

1. Дорноговь аймаг дахь шүүхийн Ёс зүйн дэд хорооны дарга А.Баяржаргал нь 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлага” сэдвээр





2. 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гомдол, мэдээлэл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх” сэдвээр





3. Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.Ариунзул 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Дорноговь аймаг дахь шүүхийн ажилтнуудад “Шүүгчийн ёс зүй” сэдвээр



4. “Ёс зүй, харилцаа хандлага” “Шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм” сэдвээр




5. “Шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлага”, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” сэдвээр



**3.4. Шүүхийн тамгын газрын ажилтны хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хүний нөөцийн мэдээллийн санг баяжуулж, ашиглах:**

Шүүхийн тамгын газрын ажилтны хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэж хэвшсэн бөгөөд 2024 оны ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтны хувийн хэргийг бүртгэлээр хүлээлгэн өгч хуулбарыг нь архивласан. Өөр байгууллагад шилжин ажиллах болсон 2 ажилтны хувийн хэргийг хууль, журмын дагуу тухайн байгууллагад нь албан бичгээр хүргүүлсэн.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

2024.10.16 № 195

танай ____ -ны № ____ -т

БАГАНУУР ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАРТ

Тус шүүхэд шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Б.Мөнх-Эрдэнэ, Н.Норжинлхам нарын хувийн хэргийн хүргүүлэв.

Хавсралт: 204 хуудас.

ДАРГА С.БУРМАА

015300424



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

2024.11.15 № 214

танай ____ -ны № ____ -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газрын үйлчилгээний хэлтэст шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан М.Оюу-Эрдэнийн хувийн хэргийн хүргүүлэв.

Хавсралт: хуудас.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ДАВААДОРЖ

**3.5. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг Монгол Улсын төрийн одон, медаль, цол, тэмдэг болон салбарын шагналд уламжлах:**

Шагналд нэр дэвшигчдийн материалыг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн.



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Л.ЭНХБИЛЭГ ТАНАА

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шагналд нэр дэвшигчдийн материал хүргүүлэх тухай

Дорноговь аймаг дахь шүүхийн хамт олны хурлаар Монгол Улсын төрийн дээд цол, одон медаль, салбарын шагналд нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Уг хурлаар нэр дэвшсэн шүүгч, ажилтнуудын шагналын анкет, ажил байдлын тодорхойлолт, хамт олны хурлын тэмдэглэлийг хүргүүлэв.

Хүлээн авч, холбогдох журмын дагуу эргэн мэдээлж, шийдвэрлэхийг хүсье.

Хавсралт 80 хуудас

Хүндэтгэсэн,

ДАРГА С.БУРМАА

**3.6. Шүүхийн тамгын газрын албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу хөтөлж, хяналт тавих:**

Тус шүүхийн тамгын газар нь нийт 27 ажилтан байхаас 25 ажилтан ажиллаж байгаа бөгөөд 25 ажилтны хувийн хэргийг журмын дагуу хөтөлж хяналт тавин ажиллаж байна. Мөн хүүхэд асрах чөлөөтэй 2 ажилтны материалыг журмын дагуу хадгалж байгаа бөгөөд шилжин томилогдсон 2 ажилтны материалыг шилжин ажиллаж байгаа байгууллагууд нь хүргүүлсэн ба ажлаас чөлөөлөгдсөн ажилтны материалыг эх хувийг ажилтанд хүлээлгэн өгч хуулбарлан авч архивт хадгалж байна.


ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗАР

Ажлаас чөлөөгдсөн албан хаагчийн хувийн хэргийг хүлээлгэн өгсөн гар бүртгэл

2024 он

**3.7. “Шүүхийн захиргааны цахим сургалтын систем”-д байршсан хичээлүүдийг бүрэн судалсан байх:**

“Шүүхийн захиргааны цахим сургалтын систем”-д байршсан хичээлүүдийг судалж эхэлсэн бөгөөд програм гацах, удаан унших, алдаа заах зэргээр бүрэн гүйцэд хамрагдах боломжгүйгээс шалтгаалж сургалтыг бүрэн судалж чадаагүй энэ талаар холбогдох хүмүүстэй уламжилсан болно.



**3.8. Шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан сургалтын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх:**

Тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/08 дугаартай тушаалаар дотоод сургалтын төлөвлөгөөг баталж нийт 13 сургалтыг зохион байгууллаа. Үүнд:


ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр Дугаар А/08 Сайншанд сум

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1.2 дахь заалт, 87 дугаар зүйлийн 87.2 дахь хэсэг, "Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 9.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газрын албан хаагчдад зориулсан дотоод сургалтын 2024 оны төлөвлөгөөг хавсралтаар батлагсугай.

2.Дотоод сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, Тамгын газрын даргад тайлагнаж ажиллахыг шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Н.Норжинлхамд үүрэг болгосугай.

ДАРГА С.БУРМАА

015100791

1. 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн “Сүрьеэ өвчний талаарх ерөнхий ойлголт” сэдвээр





2.2024 оны 02-р сарын 26-ны өдөр Дорноговь аймгийн Татварын гарын мэргэжилтэн “Татварын хөнгөлөлтийн талаарх” сэдвээр



3.2024 оны 03-р сарын 20-ны өдөр Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн Т.Улаанаа “Эрүүл зөв хооллолтын талаар” сэдвээр





4.Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын дэргэдэх Эцэг эхийн зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний дагуу 2024.04.17-ны өдөр зөвлөлийн гишүүн, шүүгчийн туслах Э.Болорцэцэг “Витамины зохист хэрэглээ” сэдвээр




5. Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын сургалтын төлөвлөгөөний дагуу 2024 оны 04 сарын 25, 2024 оны 05-р сарын 08-ны өдрүүдэд Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын ажилтнуудаас монгол хэл бичгийн сорил авч түвшинг тогтоож “Эх хэл” “Үндэсний бичиг” сэдвээр





6. 2024 оны 05-р сарын 03-ны өдөр Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдварын тасгийн их эмч Э.Нямсүрэн эмч “Элэгний бүтэц, үйл ажиллагаа, элэгний эмгэгийн үед илрэх шинж тэмдэг” сэдвээр





7.Аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ-ийн дэмжлэгтэйгээр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр СЭМҮТөвийн их эмч Ш.Сугармаа “Хорт зуршил”, “Бухимдал тайлах аргууд” сэдвээр



8.Хүний Эрхийн Үндэсний комиссын Дорноговь аймаг дахь референт Т.Мөнгөнчулуун 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Дорноговь аймаг шүүхийн Тамгын газрын албан хаагчдад “Хүний Эрхийн Үндэсний байгууллагын үйл ажиллагааны чиглэл”-ийн талаар мэдээлэл өгөв. Цаашид Хүний Эрхийн Үндэсний комиссын үйл ажиллагаа, чиг үүрэг болон хүний эрхийг хүндэтгэх, хангах, соён гэгээрүүлэх, хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр талаар сургалт зохион байгуулж, хамтран ажиллахаар боллоо.




9. 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын дэргэдэх Эцэг, эхийн зөвлөлийн урилгаар Дорноговь аймгийн Сайншанд сумын лаборатори 2 дугаар сургуулийн сэтгэл зүйч Н.Буянцэцэг шүүхийн Тамгын газрын албан хаагчдад “Хүүхэд насны онцлог” сэдвээр



10. Шүүхийн ерөнхий зөвлөлийн сэтгэл зүйч Т.Энхгэрэл 2024 оны 06-р сарын 26-ны өдөр шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарт “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн сэтгэл зүйн онцлог” сэдвээр





11. Шүүхийн ерөнхий зөвлөлийн сэтгэл зүйч Т.Энхгэрэл 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр “Сэтгэл зүйн онцлог” сэдвээр



12. Монгол даатгалаас 2024 оны 06-р сарын 27-ны өдөр “Амь насны даатгал” “Тээврийн хэрэгслийн даатгал” сэдвээр



13. 2024 оны 10 дугаар сарын 13-ны өдөр шүүхийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч нарт “Томуу, томуу төст өвчний өнөөгийн байдал, урьдчилан сэргийлэх арга” сэдвээр



**3.9. Шүүгчийн хүний нөөцийн программд холбогдох мэдээ, мэдээллийг бүрэн бүртгэж, баяжилтыг тухай бүр хийж, энэ талаар шүүгчид хагас, бүтэн жилээр танилцуулах:**

Шүүгчийн хүний нөөцийн программд холбогдох мэдээ, мэдээллийг бүрэн бүртгэж, баяжилтыг тухай бүр хийж, энэ талаар шүүгчид хагас жилээр танилцуулан баталгаажуулан 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн



Дорноговь аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүгч нарын хүний нөөцийн систем дэх мэдээллийн танилцсан баталгааны хуудас

Огноо: 2024.05.31

| № | Шүүгчийн нэрс | Албан тушаал | Мэдээлэлтэй хянаж танилцсан эсэх | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | А.Сайнтөгс | Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч | + | |
| 2 | Н.Болормаа | Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч | + | |
| 3 | С.Отгонтуяа | Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч | + | |
| 4 | Б.Цэнд | Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч | + | |
| 5 | Б.Сайнзаяа | Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч | + | |
| 6 | Б.Байгалмаа | Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч | + | |
| 7 | Д.Адъяасүрэн | Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч | + | |
| 8 | Б.Одбаяр | Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч | + | |
| 9 | Д.Наранцэцэг | Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч | + | |
| 10 | Ц.Ариунзул | Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч | + | |
| 11 | Б.Гончигсумлаа | Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч | + | |

ТАНИЛЦУУЛСАН: Т.ДАВААДОРЖ

**Дүн шинжилгээ**

Шүүхийг хүний нөөцөөр хангах чиг үүргийн хүрээнд Төрийн албаны тухай хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөн албан хаагч шинээр томилох, шатлан дэвшүүлэх арга хэмжээ авч шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан орон тооны хязгаарт хүргэж ажиллах бодлого баримталж ажиллалаа.

Мэдээлэл технологийн мэргэжилтэн албан тушаалаас 2022 онд чөлөөлөгдсөн. Одоогоор Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хавсран гүйцэтгэж байгаа учир мэргэжлийн түвшинд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд учир дутагдалтай байдаг. Харин гарын авлагаас өөрийн боломжоор судлан техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна. Мэдээлэл технологийн мэргэжилтэн сул орон тоог нөхөх тусгай шалгалтад иргэд бүртгүүлдэггүй, IT мэргэжилтэй төгсөгчдийг урьж ажлын байр санал болгоход ерөнхий шалгалт өгөхөөс төвөгшөөдөг, мөн төрийн үйлчилгээний ангилалд авч ажиллуулж байгаа байгууллага, эсвэл гэрээний үндсэн дээр ажиллах байгууллагатай хамтрах хандлагатай байдаг.

**ДӨРӨВ. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ**

### 4.1. Шүүгчээс хөтөлсөн нөлөөллийн мэдүүлэг, тэмдэглэлийг холбогдох журамд заасны дагуу нууцлалыг хангаж, Ерөнхий зөвлөлд хүргүүлэх, нөлөөллийн мэдүүлэгт нотлох баримт бүрдүүлэхэд шүүгчид дэмжлэг үзүүлэх:

Тайлант хугацаанд уг зөрчил гараагүй бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бэлтгэн гаргасан гарын авлагыг шүүгч нарт танилцуулсан бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Тагнуул ерөнхий газрын Дорноговь аймаг дахь хэлтсээс “Хавтаст хэрэгт ирсэн нууц баримт бичгийг ашиглах, хадгалах” сэдвээр сургалтыг зохион байгуулсан. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бэлтгэсэн гарын авлагыг шүүгч нарт тарааж танилцуулсан.







ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

ШҮҮХ, ШҮҮГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ХОЛБОГДОХ ЖУРАМ, ТУШААЛ, ЗААВАР

2024 он



ГАРЧИГ

Нэг. Монгол улсын хууль зүй дотоод хэргийн сайд, шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан тушаал....1
Хоёр. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Цагдаагийн Ерөнхий газрын даргын хамтарсан тушаал....5
Гурав. Шүүгчийн бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх, хадгалах заавар....6
Дөрөв. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал....9
Тав. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үе хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам....10
Зургаа. Монгол улсын хууль зүй дотоод хэргийн сайд, шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан тушаал....14
Долоо. Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч,, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам....15
Найм. Яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, хохирогч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах журам....27

**4.2. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3, 44.4 дэх хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон бол Ерөнхий зөвлөлд нэн даруй мэдэгдэх:**

Тайлант хугацаанд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3, 44.4 дэх хэсэгт заасан нөхцөл байдал гараагүй болно.

**4.3. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд уг шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, энэ талаар Ерөнхий зөвлөлд нэн даруй мэдэгдэж, холбогдох арга хэмжээ авах:**

Тайлант хугацаанд Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдол гараагүй байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон Онцгой нөхцөл байдлын үед хамтран ажиллах төлөвлөгөөг батлан гаргалаа.


БАТЛАВ:
ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕД ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.07.01 Сайншанд


БАТЛАВ
ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.БУРМАА

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН: АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ, ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ, ДЭД ХУРАНДАА А.СЭРГЭЛЭН

БОЛОВСРУУЛСАН: ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ДАВААДОРЖ

2024 ОН

**4.4. Цагдаагийн байгууллагатай “Хамтран ажиллах төлөвлөгөө”-г баталж, хэрэгжүүлэх:**

2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Дорноговь аймгийн цагдаагийн газартай 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөө батлан төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.



БАТЛАВ:
ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА С.БУРМАА

БАТЛАВ:
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЦАГДААГИЙН
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД
ХУРАНДАА Б.БАТЭОРИГ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР, ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2024 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.01.10 Сайншанд сум

Зорилго: Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/166/65 дугаартай тушаалын хавсралтаар баталсан "ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДЭГ САХИУЛАХ, ШҮҮХ, ШҮҮГЧ, ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮН, ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ", "ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧИЙГ ХУЯГЛАН ХҮРГЭХ, ШҮҮХИЙН ДУУДСАНААР ИРЭХГҮЙ БАЙГАА ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧ, ГЭРЧ, ЗОХИГЧ, ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИЙГ АЛБАДАН ИРҮҮЛЭХ, ШҮҮХЭЭС ОРГОН ЗАЙЛСАН ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧ, ЯЛТНЫГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ ЖУРАМ"-ын хэрэгжилтийг ханган ажиллахад оршино.

| д/д | Төлөвлөсөн ажил | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|
| **Нэг. Шүүх, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд** | | | |
| 1.1 | Шүүх, шүүхийн барилга байгууламжийг 24 цагаар харуул хамгаалалтад байхаар зохион байгуулж, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдал, хамгаалалтыг хариуцах, шүүхийн байранд иргэдийг нэвтрүүлэх хөдөлгөөнд нь хяналт тавих үүрэг бүхий шүүхийн байрны харуулын цагдааг томилон үйл ажиллагаанд нь өдөр тутам хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах | Жилдээ | ШЗБХМ Н.Норжинлхам, НХЖХТ-ийн дарга |
| 1.2 | Шүүх хуралдааныг өөр газар явуулах /цагдан хорих байр, нүүдэллэн ажиллах г.м/ болон "Сахилгын хороо"-ны хуралдаанд шүүгч оролцох үеийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг шүүхийн тамгын газартай хамтран зохион байгуулах. | Тухай бүр | Шүүхийн тамгын газар, Цагдаагийн газар |
| 1.3 | Онцгой нөхцөл байдал үүссэн үед учрах эрсдэл, аюулыг зайлуулах, түүний хохирлыг багасгах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шүүхийн байрыг хүч нэмэгдүүлэн хамгаалалтад авах | Тухай бүр | Шүүхийн тамгын газар, Цагдаагийн газар |

**4.5. Шүүгчийг хуулиар зөвшөөрсөн бие хамгаалах тусгай хэрэгсэл ашиглах талаар холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах:**

Шүүгчийг хуулиар зөвшөөрсөн бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрхэн хэрэглэх талаарх сургалтыг 2024 оны 2024 оны 10 дугаар с арын 28-ны өдөр Дорноговь аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгууллаа.



**4.6. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах ажлыг холбогдох журамд заасны дагуу цагдаагийн байгууллагатай хамтран шуурхай зохион байгуулж, энэ талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд даруй мэдэгдэх:**

Тайлант хугацаанд шүүгчээс Ерөнхий зөвлөлд хандан гаргасан хүсэлт байхгүй болно.

**4.7. Шүүх хуралдааны аюулгүй байдлыг зохих журам, стандартын дагуу хангах, шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах:**

Шүүх хуралдааны аюулгүй байдлыг зохих журам, стандартын дагуу хангах, шүүх хуралдааны дэг сахиулах ажлын аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн санхүүжилтээр драгер багаж, шүүх хуралдаанд оролцогчдын гар тээшийг хадгалах шүүгээ, шүүх хуралдааны танхимд сүлжээ сарниулагч авч байршууллаа.








Мөн шүүгчийг томилолтоор явах үед тухай бүр шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажлыг Цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулж шүүгч бүрэлдэхүүнд өөр аймаг руу явах тохиолдолд 23 албан бичгийг цагдаагийн газар луу хүргүүлж байнгын хамгаалалтад явж хэвшсэн.




**4.8. Албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаанд тогтмол хяналт тавьж, цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах, журамд заасны дагуу албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагааны мэдээллийг цагдаагийн байгууллагаас тухай бүр авч, дүн шинжилгээ хийж, тухайн шүүхэд улирал тутамд танилцуулах:**

Албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаанд тогтмол хяналт тавьж, цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах, журамд заасны дагуу албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагааны мэдээллийг цагдаагийн байгууллагаас 1 улирлын байдлаар авч танилцуулсан бөгөөд улмаар хяналтыг улам сайжруулах үүднээс  сар бүр дэлгэрэнгүй судалгааг авч хяналтыг тавьж байна. Мөн дотооддоо 7 хоног бүрийн шуурхай хуралдаанд 7 хоногийн мэдээнд тулгуурлан хяналтыг тавьж байна.



Дорноговь аймгийн Шүүхийн тамгын газарт

| № | Нэхэмжлэгч | Хариуцагч | Шийдвэрийн дугаар, огноо, сар өдөр | Шүүгч | Биелэгдсэн эсэх |
|---|---|---|---|---|---|
| | Бүрдэнэ булаг ХХК | Д.Отгонсайхан | 136/шш2024/00327 | Ц.Ариунзул | Биелэгдээгүй Хариуцагч этгээдийг Цагдаагийн байгууллагын Эрэн сурвалжлах АСАП санд шүүхээс даалагсан төлөвт 0000108 дугаараар улсын хэмжээнд зарлаж ажилласан. Хариуцагч Д.Отгонсайхан 2024 оны байдлаар нийгмийн даатгал төлсөн бүртгэлгүй одоогийн байдлаар тодорхой эрхэлсэн ажилгүй байна. |
| 2 | Ш.Уртнасан | Т.Чулуунбаатар | 136/шш2024/00328 | Ц.Ариунзул | Биелэгдээгүй Хариуцагч этгээдийг Цагдаагийн байгууллагын Эрэн сурвалжлах АСАП санд шүүхээс даалагсан төлөвт дугаараар улсын хэмжээнд зарлаж ажилласан. Хариуцагч Т.Чулуунбаатар нь 2024 оны байдлаар нийгмийн даатгал төлсөн бүртгэлгүй одоогийн байдлаар тодорхой эрхэлсэн ажилгүй байна. |

Судалгаа гаргасан: а/ч О.Уламбаяр

**4.9. Шүүгч, ажилтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах ажлыг зохион байгуулж, холбогдох тайлан мэдээг батлагдсан маягтын дагуу шуурхай ирүүлэх:**

Шүүгч, ажилтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах ажлыг зохион байгуулж, холбогдох тайлан мэдээг батлагдсан маягтын дагуу 2023 оны мэдүүлгийг тамгын газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 33 тоот албан бичгээр хүргүүлсэн. ХАСХОМ гаргах нэрсийн жагсаалтыг 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР
44101 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Дорноговь аймгийн шүүхийн байр,
Утас/Факс: (976) 70522339
E-mail: dornogovi_tg@shuukh.mn

2024.02.20 № 33
танай ______ -ны № ______ -т

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛД

Дорноговь аймаг дахь шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Тамгын газрын даргын 2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлсэн тухай баталгааны маягт, мэдүүлэг гаргавал зохих шүүхийн захиргааны албан хаагчдын мэдүүлгийн тайланг хүргүүлэв.

Хавсралт: 18 хуудас

ДАРГА С.БУРМАА

015300037

**4.10. Шүүгчийн хараат бус байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд хандсан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах: гарын авлага**

Шүүгчийн хараат бус байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд хандсан соён гэгээрүүлэх ажлыг Зүүнбаян баян болон 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр “Хуульчийн про боно өдөрлөг, аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын талбайд зохион байгуулагдсан гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа газруудын “нээлттэй хаалганы өдөрлөгт” иргэдэд сурталчилсан.

**ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Шүүгч, шүүхийн аюулгүй байдлыг “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх шүүгч шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”, “Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам” холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган Дорноговь аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хамгаалалтын цагдаа 2, харуулын цагдаа 3, хэв журмын ахлах байцаагч 1, нийт 6 алба хаагч шүүхийн байрны харуул хамгаалалтыг хариуцаж ажиллаж байна. Цагдаагийн газрын хүний нөөцийн хувьд дутмаг байдгаас харуулын цагдаа байнга солигддог, одоогоор шүүх хуралдааны дэг сахиулагч орон тоон дээр хүнгүй байгаа.

**ТАВ. ШҮҮХИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР**

**5.1.Батлагдсан төсөв, цалингийн сан, орон тоонд багтаан төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулах, бүртгэх, тайлагнах ажлыг зохион байгуулах:**

Шүүхийн тамгын газрын 2024 оны жилийн нийт батлагдсан төсөв 2,352,713,100.00 төгрөг бөгөөд 11 дүгээр сарын байдлаар тайлант үеийн батлагдсан төсөв 2,142,054,600.00 төгрөг үүнээс 1,823,139,557.85 төгрөгийн төсвийн зарцуулалт хийгдэж 318,915,042.15 төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна. Нийт төсвийн 85.1 хувийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан. Батлагдсан төсвийн 78.1 хувь буюу 1,674,573,620.40 төгрөгийг цалин болон нийгмийн даатгал үлдсэн 6.9 хувь буюу 148,565,937.45 төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардлууд эзэлж байна. Мөнгөн хөрөнгийн 100060005001 тоот харилцах дансны баримтыг сар бүрээр анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж байна.

**5.2.Шүүхийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, норм стандартын дагуу үндэслэлтэй боловсруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх:**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-т заасны дагуу шүүхийн тамгын газрын 2025 оны төсвийн төслийн саналыг 3,888,526,606.90 төгрөг. Үүнээс цалин, нийгмийн даатгалд 3,549,727,609.9 төгрөг, хангамжийн материал, урсгал засвар

болон үйл ажиллагаанд 338,798,997.00 төгрөг. Төсвийн бодит хэрэгцээ шаардлага, норм стандартын дагуу үндэслэлтэй боловсруулж Төсвийн ерөнхийлөн захирагчид 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлсэн байна.

**5.3.Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг иж бүрэн, үнэн зөв, хуульд заасан хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид сар, улирал бүр хүргүүлэх:**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу 2023 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлан, 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг цаасаар, 1 болон 3 дугаар улирлын санхүүгийн тайланд харилцах дансны үлдэгдэл, тооцоо нийлсэн акт, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 388 тоот тушаалаар батлагдсан аргачлалаар тайлагнан цахимаар болон шуудангаар дээд шатны байгууллагад хүргүүлдэг. Шүүхийн улирал бүрийн санхүүгийн тайланг www.e-report.mof.gov.mn цахим санд хуульд заасан хугацаанд үнэн зөв нэгтгэн ажилласан. 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг цахим хэлбэрээр төсвийн ерөнхийлөн захирагчид болон цаасан хэлбэрээр төрийн сангаар баталгаажуулан ажиллаж байна.

**5.4.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах:**

2024 оны санхүүгийн анхан шатны баримтыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бүрдүүлэн эмхэтгэн ажиллаж байна.

**5.5.Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангах:**

2024 оны хагас жилийн байдлаар шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж, улирал бүр хөрөнгийн тайлан гаргаж, хагас болон бүтэн жилээр тооллого хийж, илтгэх хуудсаар хүргүүлдэг.

**5.6.Ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах, шилжүүлэх эсхүл худалдах асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлүүлж, биелэлтийг хангаж ажиллах:**

2024 онд актлах үндсэн хөрөнгө 4 ширхэг, ашиглалтын хугацаа сунгах үндсэн хөрөнгө 110 ширхэг нийт 50 нэр төрөл бүхий үндсэн хөрөнгийг жагсаалт холбогдох материалуудын хамтаар дээд шатны байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр явуулсан.

**5.7.Цалин хөлс, татвар, даатгалын тайлангийн уялдааг хангаж, өр, авлагагүй ажиллах:**

Тус шүүхийн санхүү нь шүүгчдийн хараат бус байдлыг хангах шүүн таслах ажлыг тасралтгүй явуулахад санхүүгийн талаас шаардлагатай арга хэмжээг тухай бүр нь авч ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 29-ний байдлаар тасалбар болгон шүүгч, шүүхийн захиргааны ажилчдын цалинг сар бүрийн 08, 22-ны өдрүүдэд

сангийн яамны Төрийн албаны цалингийн нэгдсэн систем /ТАЦНС/-ээр тогтмол бодож олгосон хэвшсэн. 2024 оны 11 дүгээр сарын 29-ний байдлаар цалин, нийгмийн даатгал, татварт нийт 1,674,573,620.40 төгрөгийн гүйлгээ хийгдэн өр, авлагагүй ажиллаж байна. Шүүхийн санхүү нь “Тооцоолох ХХК”-ийн, Acolous программаар, цалингийн тооцооллыг www.payroll.gov.mn /Төрийн албаны цалингийн нэгдсэн систем/, www.finance.gov.mn /цахим гүйлгээний программ/, www.portal.ndaatgal.mn /нийгмийн даатгалын программ/, www.etax.mta.mn /татварын нэгдсэн программ/-аар өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

**5.8. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд www.shilendans.gov.mn сайтад үнэн зөв, иж бүрэн байршуулахад хяналт тавих:**

“Шилэн дансны тухай хууль”-д заасны дагуу Шүүхийн 2024 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэл, төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгаан тайлбар, санхүүгийн тайлан, аудитын тайлан, жилийн батлагдсан төсөв, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, байгууллагын батлагдсан орон тоо зэрэг шаардлагатай мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан. Тус шүүхийн тамгын газар нь 2024 оны 11 дүгээр сарын 29-ний байдлаар Сар бүр оруулах 40, хагас болон бүтэн жил бүр оруулах 9, тухай бүр оруулах 110 мэдээлэл нийт 148 мэдээлэл оруулхаас 147 мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээллэж, 1 мэдээлэл хугацаа хоцорч мэдээллэсэн байна.

Зураг-1: Шилэн дансны цахим сайтаас



Тухай бүр

| | | | | |
|---|---|---|---|---|
| 20 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ | - | | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ |
| 21 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ | - | | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ |
| 22 | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | - | 7 хоногийн дотор | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ |
| 23 | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг | - | | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ |
| 24 | Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл | - | | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ |
| 25 | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн | - | | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ |
| 26 | Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төлөвлөгөө тайлбар, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт | - | | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ |
| 27 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдүүлэл | - | | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ |
| 28 | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | - | | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ |

Тухай бүр /Хуулиар заавал оруулах шаардлагагүй/

| | | | | |
|---|---|---|---|---|
| 29 | Хавсралт файлууд | - | | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ |



Хүснэгт-1: Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан үндсэн хөрөнгө:



| Д/д | Бараа, ажил үйлчилгээний нэр | Тоо ширхэг | Төсөвт өртөг /төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| 1 | Хард 10TB HDD 3.5 | 1 | 950,000.00 |
| 2 | Хард дагалдах | 1 | 95,000.00 |
| 3 | Дуу хураагч | 4 | 620,000.00 |
| 4 | Нөөтбүүк 2024 | 1 | 2,740,000.00 |
| 5 | Тог баримгч | 2 | 460,000.00 |
| 6 | Принтер 1188а | 5 | 2,640,000.00 |
| 7 | Агаар хөргүүр сэнс | 3 | 1,243,410.00 |
| | НИЙТ ДҮН | 17 | 8,748,410.00 |

Хүснэгт-2: Дээд шатны байгууллагаас шилжүүлэн авсан үндсэн хөрөнгө:

| Д/д | Бараа, ажил үйлчилгээний нэр | Тоо ширхэг | Төсөвт өртөг /төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| 1 | Бичлэг хадгалах сервер | 1 | 12,144,912.20 |
| 2 | Бичлэг хадгалах серверийн хард | 2 | 2,839,341.48 |
| 3 | Зөөврийн компьютер | 11 | 28,458,320.00 |
| 4 | Шууд дамжуулалтын камер | 1 | 2,285,490.00 |
| 5 | Шууд дамжуулалтын төхөөрөмж | 1 | 3,690,750.00 |
| 6 | Шуудангийн богц /жижиг/ | 4 | 449,200.00 |
| 7 | Шуудангийн богц /том/ | 2 | 249,000.00 |
| 8 | Шуудангийн богцны лац | 1 | 55,000.00 |
| 9 | Шуудангийн богцны цоож | 6 | 79,200.00 |
| НИЙТ ДҮН | | 29 | 50,251,213.68 |

Хүснэгт 3:ГХУСАЗСЗөвлөлийн салбар зөвлөлийн дэмжлэгээр авсан үндсэн хөрөнгө:



| Д/д | Бараа, ажил үйлчилгээний нэр | Тоо ширхэг | Төсөвт өртөг /төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| 1 | Сүлжээ унагагч | 1 | 2,300,000.00 |
| 2 | ШКАФ SL99 | 1 | 702,000.00 |
| 3 | Тандагч | 1 | 925,000.00 |
| 4 | Буйдан | 1 | 599,900.00 |
| 5 | НОМ | 1 | 199,999.50 |
| 6 | Тавилга | 1 | 558,100.00 |
| 7 | Тавиур | 1 | 790,000.00 |
| 8 | Дэлгэц 21" | 1 | 425,000.00 |
| 9 | Процессор 3000 | 1 | 2,500,000.50 |
| НИЙТ ДҮН | | 9 | 9,000,000.00 |

**5.9. Бусад урсгал засварын ажил:**

Хүснэгт-4: 2024 онд хийгдсэн засварын ажил:

| Д/д | Хийгдсэн ажил | Төсөвт өртөг /төгрөгөөр/ |
|---|---|---|
| 1 | Архивын өрөөний засвар | 1,012,250.00 |
| 2 | Цонхны засвар | 9,180,200.00 |
| 3 | Шүүгч нарын өрөөний засвар | 14,000,370.00 |
| 4 | Шат, ханны засвар | 15,000,000.00 |
| 5 | Агааржуулалт, шугамын засвар | ШЕЗ ийн хөрөнгөөр |
| НИЙТ ДҮН | | 39,192,820.00 |

Засвар-1: Архивын өрөөний засвар:






Засвар-3: Шүүгч болон эвлэрүүлэн зуучлагч, уулзалтын өрөөний засвар:






Дотор шатны засварын ажил




1 давхрын коридорын засвар:






Засвар-4: Шугам, агааржуулалтын засвар:



Засвар-5: Хаалга, цонх болон дээврийн амлагаа хийв:





**Сантехникийн засвар**




**5.10. Бусад ажил:**

2024 оны 02 дугаар сарын 08, 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд шүүхийн өндөр настнуудад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг болон 1,260,000.00 төгрөгийн мөнгөн урамшуулал мөн 1,350,000.00 төгрөг олгосон.

Шүүхийн өндөр настан Д.Чимэдрэгзэн гуайн төрсөн охин нас барахад шүүхийн тамгын газраас 300,000.00 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн болно.

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг УСНББОУ стандарт, ШЕЗ-ийн СХОГ-аас 2020 онд судалж боловсруулан гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтын дагуу НББ-ийн данс тооцооны боловсруулалт хийж, төсвийг үр ашигтай зарцуулж ажилласан. НББББББ-ыг шинэчлэгдсэн, өөрчлөлт орсон хууль, тогтоомж, журмын дагуу тухай бүр нь өөрчлөлт оруулж баяжуулан ажилласан.

Тус шүүхийн 2023 оны багаж, техник, хэрэгслийн зардлыг 12,0 сая төгрөгөөр баталж үүнээс шүүх хуралдааны зааланд 75”-тэй телевизор болон PAPOO C280 web камер суурилуулсан нь шүүх хуралдаанд оролцож буй хэргийн оролцогчтой zoom хурлаар ороход дуу дүрсний өндөр нягтаршилтай zoom-ээр шүүх хуралдаанд оролцох болсон. Мөн 28 ширхэг SSD Hard худалдан авч шүүгч болон шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хурлын заал, архив бичиг хэргийн

эрхлэгч нарын компьютерт суурилуулснаар гацалтгүй түргэн шуурхай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллалаа.

Шүүхийн барилгын халаалтын систем нь ашиглах хугацаа дууссан дулаан алдалттай халаалт муу болсонтой холбоотой халаалтын систем шинэчлэх болсон тул Шүүхийн ерөнхий зөвлөлд мэдэгдсэнээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн зарласан тендерт шалгарсан “омбо Илч” ХХК нь халаалтын систем бүрэн хийж гүйцэтгүүлсэн.

**ЗУРГАА. МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР**

**6.1. Шүүх өөрийн цахим хуудсаар шийдвэр, үйл ажиллагаагаа тогтмол мэдээлж ажиллах:**

Нийт 68 шүүхийн шийдвэр болон процессын тойм үйлажиллагын бэлтгэж http://www.court.do.gov.mn/ цахим хуудас болон пэйж хуудсаар түгээсэн. Үүнд Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрийн тойм 12, процессын тойм 5, Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шийдвэрийн тойм 5, процессын тойм 6 Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс -шийдвэрийн тойм 7, процессын тойм 7, Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх шийдвэр болон процессын-0 тойм бусад мэдээлэл 26-ийг тус тус оруулсан.



**6.2. Шүүх хуралдааныг хуульд тусгайлан заасанаас бусад тохиолдолд нээлттэй явуулах:**

Шүүх хуралдааныг хуульд тусгайлан заасанаас бусад тохиолдолд нээлттэй явуулж байна.



**6.3. Шүүхийн шийдвэрийг ойлгомжтой байдлаар олон нийтэд тухай бүр, шуурхай мэдээлж, статистик мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх:**

Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын сайт болон пэйж хуудсанд шүүхийн шийдвэрийн тоймыг ойлгомжтой байдлаар олон нийтэд хүргэж байна.



**6.4. Хуулиар хориглосноос бусад тохиолдолд шүүх хуралдааныг “Шүүхийн мэдээ” цахим хуудсаар олон нийтэд хүргэх:**

Хуулиар хориглосноос бусад тохиолдолд олны анхаарал татсан 1 шүүх хуралдааны “Шүүхийн мэдээ” цахим хуудас болон шүүхийн шийдвэрийн тоймыг өөрийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэсэн.

**6.5. Шүүгч ажилтны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, нийтлэлийг бүртгэж, тухайн шүүхийн шүүгчдэд танилцуулах, холбогдох арга хэмжээ авах:**

Шүүгч ажилтны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, нийтлэл гараагүй болно.

**6.6. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшинг тодорхойлох судалгаа хийж, тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх:**

Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшинг тодорхойлох судалгааг 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 132 иргэнээс санал авахад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 119 хувь шүүхэд итгэдэг 13 хувь нь итгэдэггүй гэсэн хариултыг өгсөн байна.




**6.7. Нээлттэй шүүх өдөрлөгийг улирал тутам зохион байгуулж, олон нийтэд шүүхийн үйл ажиллагааг сурталчлах:**

“Хуульчийн про 2024” арга хэмжээнд 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр оролцож иргэдэд шүүхийн үйл ажиллагааг танилцуулж, 32 иргэнд брошюр гарын авлага материал тараасан.



Дорноговь аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын талбайд зохион байгуулагдсан гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа газруудын “нээлттэй хаалганы өдөрлөгт” тус шүүхийн тамгын газрын албан хаагчид оролцож шүүхэд хэрхэн нэхэмжлэл, өргөдөл гомдол, хүсэлт гаргах, зөрчигдсөн эрхээ хэрхэн хамгаалуулах, талаар иргэдийн сонирхсон асуултад хариулж, арга зүйн зөвлөгөө өгч 46 иргэнд гарын авлага тарааж ажиллалаа.



**6.8. Иргэдийн эрх зүйн боловсролд зориулсан мэдээллийг улирал тутамд олон нийтэд түгээх:**

Иргэдийн эрх зүйн боловсролд зориулсан мэдээллийг улирал тутамд олон нийтэд түгээх ажлын хүрээнд 7 удаагийн сургалт сурталчилгааны ажлыг аймгийн төрийн болон хувийн хэвшил, иргэдэд зориулан хүргэсэн.

Мөн өөрсдийн пэйж хуудас болон цахим хуудсаар иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор мэдээллийг хүргэн ажиллаж байна.




**Дүн шинжилгээ**

Шүүхийн веб сайт, facebook хуудсанд үйл ажиллагааны мэдээ мэдээлэл, тайлан мэдээ, шүүн таслах ажлын мэдээ, шүүх хуралдааны зар, тоймыг нийтлэн ажиллаж байна. Мөн шүүхийн байрны гадна талд байршуулсан гэрэлт самбарт байршуулсан Qr кодыг уншуулан Тамгын газрын веб сайтаас шүүхэд нэхэмжлэл, эвлэрүүлэн зуучлалд гаргах өргөдлийн загвар, холбоо барих утасны дугаар гэх мэт өөрт хэрэгцээтэй мэдээллийг хүссэн үедээ авах боломжийг бүрдүүллээ.

**ДОЛОО: БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:**

**1.** Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газраас санаачлан Захиргааны хэргийн дагнасан шүүхийн 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд хамтран 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор “ВОЛЛЕЙБОЛ”-ын тэмцээн зохион байгууллаа.



2. Захиргааны хэргийн дагнасан шүүхийн 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2024 оны 05 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 10 дугаар ангийн сурагчдад “Өглөөний уулзалт” хөтөлбөр арга хэмжээ зохион байгуулж, захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны онцлогийн талаар мэдээлэл өгч, сурагчдын сонирхсон асуултад хариулт өглөө.



Мөн Захиргааны хэргийн дагнасан шүүхийн 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Захиргааны шүүх 20 жил” сэдэвт түүхийн танилцуулга, гэрэл зургийг үзэсгэлэнг зохион байгуулж Захиргааны шүүх байгуулах тухай хууль тогтоомж, эх сурвалж, тус шүүхийн 20 жилийн хугацааны шүүн таслах ажиллагааны тойм мэдээлэл, 20 жилийн түүхийг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэнг болон видео шторкыг бэлтгэн пэйж хуудсаар нийтэд хүргэлээ.







3. Аймгийн Засаг даргын тамгын газраас 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчдад зориулсан хамтарсан сургалтад оролцлоо.



4. Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газраас “Байгалиа хамгаалъя” аяны нэгдэж тус аяны хүрээнд ашигласан батарейг цуглуулах хайрцаг байршуулж шүүхийн байранд байршуулж пэйж хуудсаар өөрсдийн бэлтгэсэн штлоркыг түгээсэн бөгөөд уг аяны хүрээнд Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газраас төрийн болон төрийн бус байгууллагуудыг дээрх аянд нэгдэж батарей цуглуулах хайрцаг байршуулахыг уриаллаа.







4. Эцэг, эхийн зөвлөл нь үйл ажиллагааныхаа төлөвлөгөөний дагуу шүүхийн Тамгын газартай хамтран “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан шүүгч, ажилтнуудын хүүхдүүдийн дунд хөгжөөнт тоглоом, уралдаант тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр наадмын төв талбайд зохион байгууллаа.





5. 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр БНХАУ-ын Эрээн хотын шүүхтэй танилцлаа.





6. Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын “Шүүхийн эрүүл мэндийн ажилтны 2024 оны төлөвлөгөө”-д тусгагдсаны дагуу элэгний В,С вирусын шинжилгээ өгч 3 удаагийн вакцинжуулалт хамрагдахаар болж 2 удаагийн вакцинжуулалтад хамрагдаад байна.





7. Сайншанд сумын Засаг даргын тамгын газраас сар бүр зохион байгуулдаг бүх нийтийн хог цэвэрлэгээнд хуваарилагдсан талбайг цэвэрлэж идэвхтэй хамрагддаг.





8. Дорноговь аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс Тамгын газартай хамтран Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын удирдлага, мэргэжилтнүүдтэй 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр уулзалт, ярилцлага зохион байгууллаа.

Уулзалтад Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.Ариунзул, Тамгын газрын дарга С.Бурмаа, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагч Б.Баттуяа, Эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслахууд, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Ш.Алимаа, Хүүхдийн эрхийн улсын байцаагч Б.Энхтуяа, мэргэжилтнүүд оролцлоо.

Оролцогчид Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр оролцох, дүгнэлт гаргахад тулгамдаж буй асуудал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйчийг оролцуулах, мөн хүүхдийн өрөөний талаар харилцан ярилцаж, санал солилцлоо.



9. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн мэдээллийг байгууллагын хүүхдийн өрөөнд байршууллаа.




10. Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газраас Сайншанд сумын ерөнхий боловсролын 1, 6 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад шүүхийн үйл ажиллагаа, зарчим, онцлогийг таниулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурагчдын мэргэжил сонголтод туслах зорилгоор “Нээлттэй шүүх” өдөрлөгийг 3 удаа зохион байгуулсан бөгөөд өдөрлөгт хамрагдсан сурагчдаар шүүхийн үйл ажиллагааны талаар асуумж бөглүүлж, Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Одбаяр, Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.Ариунзул, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Даваадорж нар “Шүүхийн тухай ойлголт, Шүүхийн эрхэм зорилго хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд чиглэх нь” сэдвээр, шүүхийн талаар мэдээлэл авах баттай эх сурвалжууд болон шүүхийн байр, орчин нөхцөл, шүүх хуралдааны танхимыг танилцууллаа.





11. Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газраас шүүхээр үйлчилж иргэд болон цагдаагийн албан хаагчийн харилцаа хандлагын талаарх мэдээллийг авах зорилгоор QR кодыг байршуулсан.







12. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 10 сая төгрөгийн санхүүжилтээр хүүхдийн өрөөг тохижуууллаа.



13. Шүүхийн академи, Улсын дээд шүүхтэй хамтран шүүгчдийн заавал судлах, мэргэшүүлэх сургалт 2024 оны 10 дугаар сарын 15-17-ны өдөр Дорноговь

аймагт болж өндөрлөлөө. Сургалт “Эдийн болон эдийн бус баялгийн эрх зүй дэх шаардах эрх, шүүхийн практик”, “Өв залгамжлалын эрх зүйн шинэлэг асуудлууд, шүүхийн практик”, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн шинэлэг асуудлууд” гэсэн сэдвээр явагдсан бөгөөд тус сургалтад Дорноговь, Дундговь, Төв, Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх болон иргэний хэргийн анхан шатны шүүх, Өмнөговь аймгийн Ханбогд сум, Дорноговь аймгийн Замын-Үүд дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн нийт 25 шүүгч хамрагдав.






14. Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газраас ханиад томууны улирал эхэлж байгаатай холбогдуулан шүүгч, ажилтнуудын дархлааг дэмжих зорилгоор витамин болон халуун аарц өгч байна.





15. Төв аймаг дахь шүүхээс төвийн бүсийн шүүхүүдийн шүүгч, ажилтан, албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдгээрийн бие бялдар, эрүүл мэндийг хөгжүүлэх, спортын авьяас, ур чадварыг нээх, биеийн тамир спортоор дамжуулан танилцах, ажлын туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх зорилготой “ЭВ НЭГДЭЛ, ЭРЧ ХҮЧ-2024” спортын 5 төрөлт тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 1-2-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан бөгөөд тус тэмцээнд Дорноговь аймгийн шүүхийн баг хамт олон гар бөмбөгийн эрэгтэй төрөлд мөнгөн медаль, сагсан бөмбөгийн эрэгтэй төрөлд алтан медаль, эмэгтэй баг хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.



16. Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газраас Дорноговь аймгийн улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран иргэний бүртгэлийн тасгийн иргэний улсын бүртгэгч Т.Булгамаа 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр урьж Дорноговь аймгийн шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны нийт 23 ажилтанд тоон гарын үсгийг үүсгэн хамтран ажиллалаа.





17. Аймгийн Насан туршийн боловсролын төвөөс хууль сахиулах байгууллагуудын хооронд 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Тунгаамал 2024” үндэсний бичгийн аварга шалгаруулах тэмцээнд тус аймаг дахь шүүхийн тамгын газраас амжилттай оролцлоо.



Тайлан бичсэн:

ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА Т.ДАВААДОРЖ